



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12 нэрийн, нийт 25,495,799.25 (хорин таван сая дөрвөн зуун ерэн таван мянга долоон зуун ерэн есөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 17,995,799.25 (арван долоон сая есөн зуун ерэн таван мянга долоон зуун ерэн есөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга Д.Түмэндэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоолгох, хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг авто тээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133001394
11-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
059 дугаар тогтоолын хавсралт

"ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ" НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ (төгрөг)								
1	Суудлын автомашин Тоёота Ланд крузер 78 маркийн (23-54 УНС улсын дугаартай, JTEEB71J307009018 арлын дугаар)	2010.05.13	ш	1	15,000,000	15,000,000.00	7,500,000.00	7,500,000.00
	Тээврийн хэрэгслийн дүн			1		15,000,000.00	7,500,000.00	7,500,000.00
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ								
2	Хувилагч, хэвлэгч, сканнер Canon iR2520	2016.06.01	ш	1	868,300	868,300.00	868,300.00	0.00
3	Сервер компьютер Dell PowerEdge R320	2016.06.01	ш	1	773,500	773,500.00	773,500.00	0.00
4	Суурин компьютер (иж бүрэн) Dell Optiplex 9020MT, Dell U2412M/24" Ultrasharp IPS LED display	2016.06.01	ш	1	434,500	434,500.00	434,500.00	0.00
5	Суурин компьютер (иж бүрэн) Dell Optiplex 3020MT, Dell U2412M/24" Ultrasharp IPS LED display	2016.06.01	ш	6	343,370	2,060,220.00	2,060,220.00	0.00
6	Өнгөт лазер принтер HP LaserJet Pro M451dn	2016.06.01	ш	1	249,600	249,600.00	249,600.00	0.00
7	Принтер HP P2055D	2009.11.01	ш	1	120,000	120,000.00	120,000.00	0.00

8	Проектор Acer X1130P DLP Projector	2010.04.08	ш	1	327,600	327,600.00	327,600.00	0.00
9	MS Surface	2018.03.01	ш	1	5,377,179	5,377,179.25	5,377,179.25	0.00
10	Суурин утасны сүлжээний аппарат Panasonic ATC KX-TES824	2009.11.11	ш	1	217,300	217,300.00	217,300.00	0.00
11	Суурин утасны аппарат Panasonic KX-T7730	2009.11.11	ш	1	32,400	32,400.00	32,400.00	0.00
12	Суурин утасны аппарат Panasonic KX-TSC11MXW	2009.11.11	ш	4	8,800	35,200.00	35,200.00	0.00
	Машин, тоног төхөөрөмжийн дүн			19		10,495,799.25	10,495,799.25	0.00
	Нийт дүн			20		25,495,799.25 (хорин таван сая дөрвөн зуун ерэн таван мянга долоон зуун ерэн есөн төгрөг хорин таван мөнгө)	17,995,799.25 (арван долоон сая есөн зуун ерэн таван мянга долоон зуун ерэн есөн төгрөг хорин таван мөнгө)	7,500,000.00 (долоон сая таван зуун мянга)